

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 24 оны 08 сарын 26-ны өдөр

№ 20

Улаанбаатар хот

Арилжааны банканд зээлийн шугамын эрх нээлгэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдад зээл олгох, зээлийн эрэлтийг хэвийн хадгалах, бизнес төлөвлөгөөний хүрээнд “Сэндли ББСБ” ХК-ийн нэр дээр М банканд дараах нөхцөлөөр зээлийн шугамын эрх нээлгэхээр тогтсугай.

Зээлийн эрхийн хэмжээ: 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг

Зээлийн эрхийн хугацаа: 12 /арван хоёр/ сар

Зээлийн хүүгийн хэмжээ: Жилийн 20.5 /хорь аравны таван/ хувь

2. Энэхүү тогтоолын 1-д заасан “Сэндли ББСБ” ХК-ийн зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 10 /арав/ тэрбум төгрөгийн дүн бүхий хэрэглээний болон үл хөдлөх эд хөрөнгийн, автомашин барьцаалсан зээлийн багцыг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Банктай зээлийн болон барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Үйл ажиллагаа хариуцсан захирал /Б.Ичинхорлоо/ нарт олгосугай.
4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл шалгалт шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/, Санхүү хариуцсан захирал /Б.Батжаргал/ нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 26-ны өдөр

№ 21

Улаанбаатар хот

Салбар нэгжийн хаяг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Улаанбаатар хот дахь Дэнжийн мянга салбарын (Салбар-19) албан ёсны оршин байгаа газрын хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Цагдаагийн гудамж, Хурд худалдааны төв, 6 давхар, 605 тоот, Өвөрхангай аймаг дахь Хархорин салбарын (Салбар-35) албан ёсны оршин байгаа газрын хаягийг Өвөрхангай аймаг, Хархорин сум, ГО 2-р баг, баг, 1 гудамж, 436 тоот болгон тус тус өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн салбар, нэгжийн хаяг өөрчлөгдөж буйтай холбоотойгоор компанийг төлөөлж Түрээсийн гэрээ байгуулах эрхийг Салбарын захирлуудад олгосугай.

3. Компанийн салбар, нэгжийн хаягийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл авах ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д, салбарын хаягийн өөрчлөлт болон түрээсийн гэрээг Улсын бүртгэлд зохих журмын дагуу бүртгүүлэхийг Салбарын захирлуудад тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ


